



Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалт, үнэлгээний газар

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

(2021 оны 5 дугаар сар)

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА

НЭГ. ТҮР ХОРОО

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

- 2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 2.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДУУСГАВАР БОЛСОН АЖЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА

- 3.1. АСУУЛГА

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ, ТОГТООЛ
- 5.2. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТҮР ХОРОО

Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судалж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий 2 түр хороо байгуулагдан ажиллаж байна.

Хүснэгт 2. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан түр хороо

| Д/д | Түр хороо байгуулсан тогтоол | Түр хорооны бүрэлдэхүүн |
|-----|---|--|
| 1. | 2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоол /КОВИД-19/ | Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Х.Болорчулуун, Ж.Мөнхбат, Н.Учрал, М.Оюунчимэг, Б.Жавхлан, Б.Чойжилсүрэн, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Б.Бейсен, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Н.Алтанхуяг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох, Х.Хэрлэн |
| 2. | 2021.3.26 №30 Түр хороог байгуулах тухай УИХ-ын тогтоол /Оюу толгой/ | Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Х.Ганхуяг, Г.Данминням, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Ж.Мөнхбат, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, С.Чинзориг, Б.Энхбаяр ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од |

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 -т тодорхой асуудлыг шалган судалж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулах



1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулагдсан. Түр хороо нийт 7 удаа хуралдав. Түр хорооны 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсов.


Мөн хуралдаанаар 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаас Улсын онцгой комисст өгсөн үүргийн биелэлт, Монголбанкнаас цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Санхүүгийн зохицуулах хорооноос цар тахлын үед зохицуулалтын салбарт хэрэгжүүлж буй ажлуудын талаарх мэдээллийг тус тус сонсов.

Тус хуралдаанаас Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хугацааг сунгах эсэх асуудлыг судлах, хөл хориог цуцалж байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон иргэдийн орон нутаг руу зорчих хөдөлгөөн нээсэнтэй холбогдуулан халдвар тархах эрсдэлээс сэргийлэх, халдвар хамгааллыг дэглэмийг мөрдүүлэх, хяналтыг сайжруулахад анхаарах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн болон санал авах өдрийн хөдөлгөөн зохицуулалт, санал авах байрны ариутгал, орц гарцыг нарийвчлан төлөвлөж зохицуулах зэрэг үүрэг, чиглэлийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханд хүргүүлэв.

2. “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо байгуулагдсан.

Түр хороо нийт 4 удаа хуралдаж тогтоолын биелэлтийг хэлэлцсэний үр дүнд Оюу толгойн 2.3 тэрбум долларын нэмэлт санхүүжилтийг дэмжихгүй байх чиглэлийг Засгийн газраас “Эрдэнэс Оюутолгой” ХХК болон “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн Монголын талын төлөөлөлд өгөх, “Оюу Толгой” компанийн нэхэмжлэлээр Лондонгийн Олон улсын арбитрын шүүхэд Монгол Улсын Засгийн газрыг хариуцагчаар татсан маргаанд сөрөг нэхэмжлэл яаралтай гаргах арга хэмжээг авахыг Засгийн газарт хуралдааны тэмдэглэлээр үүрэг, чиглэл болгохоор тогтов.

Түр хорооны 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Оюу толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хийх хэлэлцээрт хуулийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ авах, хөндлөнгийн аудит хийлгэх талаар



хэлэлцэв. Тус зөвлөх үйлчилгээ үзүүлэх багт олон улсын гэрээ, хэлэлцээр, төсөв, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлагатай хууль, эрх зүйн болон бусад холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдүүлж ажиллуулахыг Засгийн газарт хуралдааны тэмдэглэлээр чиглэл болгож 16/4397 тоот албан бичиг хүргүүлэв.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2021 оны 5 дугаар сарын байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт **14 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 99 гишүүн** ажиллахад Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Нийт 14 ажлын хэсгээс:


- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 5,
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 8,
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсэг үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

2021 оны 5 дугаар сард шинээр байгуулагдсан ажлын хэсэг 1 байна. Үүнд:

1. Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн №33 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байна.

График 1. 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж буй ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (6)
- 2020 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан (2)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (6)



Хүснэгт 1. 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж буй ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

| Хугацаа | УИХ-ын даргын захирамж | Байнгын хорооны тогтоол | Дэд хорооны тогтоол |
|--|------------------------|-------------------------|---------------------|
| 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан | - | 5 | 1 |
| 2020 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан | 2 | - | - |
| 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан | 3 | 3 | - |
| Нийт - 14 | 5 | 8 | 1 |

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ



2021 оны 5 дугаар сарын байдлаар Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 5 ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанаас онцолбол:

1. Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн №33 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байна.

Ажлын хэсэг 2021 оны 5 дугаар сарын 11 болон 17-ны өдрүүдэд хуралдав. Хуралдаанаар Ардчилсан намын дотоод нөхцөл байдлын талаарх мэдээллийг сонсож, ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.

Ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу улс төрийн өнөөгийн үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулан Ардчилсан намын тамга, бүртгэл, Ерөнхийлөгчийн сонгуулийн бүртгэл зэрэг асуудлаар УБЕГ, УДШ-ийн Тамгын газар, СЕХ, АТГ зэрэг байгууллагуудад тайлбар мэдээлэл авахаар албан бичгийг хүргүүлж 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар УБЕГ, СЕХ-ноос ирүүлсэн албан бичгийн талаарх тайлбар, мэдээллийг сонсож, ажлын хэсгийн гишүүд асуулт асууж, хариулт авав.

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

| Д/д | Ажлын хэсэг байгуулсан захирамж | Ажлын хэсгийн бүрэлдэхүүн |
|-----|---|---|
| 1. | 2021.3.02 №16 захирамж Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн |
| 2. | 2021.3.11 №18 захирамж Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Ундрэм О.Цогтгэрэл ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Д.Гэрэлт-Од |
| 3. | 2021.3.18 №21 захирамж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн |
| 4. | 2021.4.08 №28 захирамж Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан, Г.Дамдинням, Ц.Сандаг-Очир, Ч.Ундрэм ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг |
| 5. | 2021.5.10 №33 захирамж Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн дэд ахлагч: УИХ-ын гишүүн Н.Ганибал Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт К.Пүрэвсүрэн |

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийх

2021 оны 5 дугаар сарын байдлаар Байнгын хорооны тогтоолоор нийт 8 ажлын хэсэг ажиллаж байгаагаас: БСШУСБХ-ны эрх асуудлын хүрээнд 1, ИЦББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 1, ТБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 3, ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 3 ажлын хэсэг тус тус ажиллаж байна. Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанаас онцолбол:

1 БСШУСБХ-ны 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд 5 дугаар сарын 12-ны өдөр Биеийн тамир, спортын улсын хороо, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор зэрэг 4 байгууллагын үйл ажиллагаатай танилцаад биеийн тамир, спортын салбарын тогтолцоог шинэчлэх, цогц бодлогоор хангах, нийтийн бие тамирыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар болов.

2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр ажлын хэсгийн гишүүд “Хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн ажлын тогтолцоо” сэдвийн хүрээнд хөдөө орон нутгийн биеийн тамирын 100 гаруй багш нарын төлөөлөлтэй цахим уулзалт-хэлэлцүүлэг хийсэн. Цахим уулзалт-хэлэлцүүлэг амжилттай явагдаж, оролцогчдын гаргасан саналыг нэгтгэн Биеийн тамир, спортын тухай хуулийн төсөлд тусган, хэлэлцүүлэхээр тогтов.

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

| Д/д | Ажлын хэсэг байгуулсан тогтоол | Ажлын хэсгийн бүрэлдэхүүн |
|--|--|--|
| Инновац, цахим бодлогын байнгын хороо | | |
| 1 | 2020.10.28-ны №02 тогтоол Эрүүл мэндийн салбар дахь цахим шилжилттэй холбоотой хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Д.Батлут, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Саранчимэг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Б.Нандингэрэл |
| Төсвийн байнгын хороо | | |
| 2 | 2020.11.04 №05 тогтоол Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд |
| 3 | 2020.12.30 №07 тогтоол Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд |
| 4 | 2021.01.20 №01 тогтоол Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын (Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай) хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг | Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од |

| Хууль зүйн байнгын хороо | | |
|---|--|--|
| 5 | <p>2020.12.24 №09 тогтоол</p> <p>Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p> | <p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Б.Нандингэрэл</p> |
| 6 | <p>2021.3.15 №07 тогтоол</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг</p> | <p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг</p> |
| 7 | <p>2021.3.15 №08 тогтоол</p> <p>Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p> | <p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг</p> |
| Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо | | |
| 8 | <p>2021.4.27 №02 тогтоол</p> <p>“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг.</p> | <p>Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг</p> <p>Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Ч.Ундрэм, Ж.Чинбүрэн, Т.Энхтүвшин</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох</p> |

2.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДУУСГАВАР БОЛСОН АЖЛЫН ХЭСЭГ

1. БОХХААБХороо Монгол Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолоор Ноён уулыг дархан цаазат газраар ангилал ахиулан улсын тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар газар дээр нь очиж ажиллахаар төлөвлөсөн боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас Байнгын хорооны хуралдаанаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээллийг цахимаар сонсов. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын хуралдаанаар улсын нөөц хөрөнгөөс Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаанд Ноён уулын дархан цаазат газрын хамгааллын менежментийг хэрэгжүүлэх, хууль бус ашигт малтмал олборлох зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх арга хэмжээг түр хариуцуулсан. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа нь Ноён уулын дархан цаазат газрын хамгааллын үйл ажиллагааг “Хамгаалах хэсэг” байгуулан хэрэгжүүлэх, менежментийн төлөвлөгөөг боловсруулах, дотоод бүсчлэлийг тогтоох, хилийн цэсийн багана, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, нутгийн иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр тогтов. Цаашид Ноён уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааг 2022 онд багтаан байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган шинээр төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөн ажиллахаар болов.

2. БСШУСБХ-ны 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих...” ажлын хэсгийн

2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар ажлын дэд хэсэг нэгдсэн тайлангаа танилцуулав. Дэд ажлын хэсэг ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийг сонгохдоо манай улсад өмнө нь хэрэгжүүлсэн ижил төрлийн төслүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, үйл ажиллагааг газар дээр нь очиж танилцах зэргээр судалгаа хийж өөрийн орны онцлог болон стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн 2 байгууламжийн шийдлийг сонгож, 5 дугаар сарын дунд үеэс үйл ажиллагаа нь эхлэх болсноо Ажлын дэд хэсгийн ахлагч, БШУЯ-ны ТНБД Д.Батбаатар танилцуулсанаар ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болов.

3. БСШУСБХ-ны 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг нийт 4 удаа хуралдав. Мөн ажлын хэсгийн хүрээнд 5 дугаар сарын 12 болон 19-ний өдрүүдэд Нийслэлийн ерөнхий боловсролын 14, 25, 58, 79 дүгээр сургуулиудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа орчин нөхцөлтэй газар дээр нь очиж танилцав. Тайланг Байнгын хорооны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Байнгын хорооноос “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тогтоолыг баталсан.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА

3.1. АСУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 асуулга тавих



2021 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх сард УИХ-ын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан тавьсан 6 асуулгын хариуг ирүүлсэн байна.

1. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журмын хэрэгжилтийн өнөөгийн байдал ба цаашид 8 хувийн хүүтэй зээлд харагдсан иргэдийн зээлийн хүүг 6 хувь болгон бууруулах боломж, нөхцөлийн талаар” тавьсан асуулгын хариуг 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдөр ХЭГ/1232 албан тоотоор;

<http://parliament.mn/n/8rson>



2. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Батлан хамгаалах салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл болон хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдөр ХЭГ/1260 албан тоотоор;

<http://parliament.mn/n/cyson>




3. УИХ-ын гишүүн Д.Ганбатаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Нүүрс тээвэрлэлтийн салбарт хэрэгжиж буй тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, цаашид Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдөр ХЭГ/1258 албан тоотоор;

<http://parliament.mn/n/moson>



4. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандан “Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт болон Ховд аймагт Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Баруун бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн өргөтгөлийг барих, эмч ажилтнуудыг сургаж, мэргэшүүлэх ажлын явцын талаар” тавьсан асуулгын хариуг 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 1а/2411 албан тоотоор;

<http://parliament.mn/n/hwsyn>



5. УИХ-ын гишүүн Ц.Туваанаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Коронавируст цар тахлын үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээд байгаа Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилтнуудад холбогдох асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг 2021 оны 5 дугаар сарын 24-ний ХЭГ/1386 албан тоотоор;

<http://parliament.mn/n/7yson>



6. УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тавьсан асуулгын хариуг 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр ХЭГ/1410 албан тоотоор.

<http://parliament.mn/n/8eson>

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д зааснаар асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгнө.

2021 оны 5 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад нийт 2 асуулга тавьсан байна.

1. УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хандан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх болон “Монгол мал-II” арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар” 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 20 тоот асуулга.

2. УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээний талаар” 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 21 тоот асуулга.

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

УИХ-аар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан мэдээлэл, тайлан, илтгэл, танилцуулгыг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй бөгөөд холбогдох Байнгын хороо харьяаллын дагуу хэлэлцдэг.

2021 оны 5 дугаар сард Байнгын хорооны хуралдаанаар нийт 6 тайлан, мэдээлэл сонссон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113, 114 дүгээр зүйл

1. Эдийн засгийн байнгын хороо 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар дараах мэдээллийг сонссон:

- Монголбанкны 2020 оны үйл ажиллагааны тайлан.

2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар дараах мэдээлэл сонссон:

- Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээлэл;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ”, түүнд холбогдох зохицуулалтын биелэлтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээлэл;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл болон хэрэгжилтийн талаар.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар дараах мэдээллийг сонссон:

- Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2021 оны төсвийн жилд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын ажлын явц байдал, цаашид боловсролын салбарт шаардагдаж байгаа хөрөнгө оруулалтын талаар болон боловсролын цахим шилжилт буюу багш сурагчдыг компьютержүүлэх үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авах ажиллагааны явцын талаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын мэдээлэл.

5.1. ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ, ТОГТООЛ


Хүснэгт 7. Хяналтад байгаа хууль тогтоомж

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар нь Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагад үүрэг, чиглэл болгосон дараах шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

| | 2021 оны 5 сарын байдлаар мэдээллийн сангийн хяналтад байгаа нийт хууль тогтоомж | 2021 оны 5 дугаар сард шинээр нэмж хяналтад авсан тогтоол |
|---|--|---|
| Хууль | 121 хуулийн 436 хэсэг, заалт | - |
| Улсын Их Хурлын тогтоол | 86 тогтоолын 275 заалт | - |
| Байнгын, дэд хорооны тогтоол, тэмдэглэл | 88 тогтоолын 484 заалт | 3 тогтоол, тэмдэглэлийн 22 заалт |

5.2. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



5.2.1. Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх:

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна. Үнэлгээний ажлын хүрээнд төлөвлөх болон хэрэгжүүлэх үе шатанд хийгдэх ажил бүрэн хийгдэж дууссан.

Мэдээлэл цуглуулах үе шатанд цуглуулсан мэдээллүүдэд баримт бичгийн болон статистик дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх үе шатны ажлууд хийгдэж байна.

Үр дагаврын үнэлгээний тайланг 6 дугаар сард дуусган танилцуулахаар ажиллаж байна.

Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх:

Номын сангийн тухай хуульд хяналт шинжилгээ хийх ажлын хүрээнд Хяналт шинжилгээний төлөвлөх үе шатны ажил бүрэн хийгдэж дууссан, хэрэгжүүлэх үе шатны ажил буюу шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг цуглуулах, боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийх зэрэг ажил хийгдэж байна. Хяналт шинжилгээний тайланг 6 дугаар сард дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай** хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх ажил батлагдсан цаглаврын дагуу 5 дугаар сард эхэлж төлөвлөлтийн буюу бэлтгэл үе шатны ажил хийгдэж, ажлын төлөвлөгөө гаргах, хуулийн архивын хувийн хэрэгтэй танилцах, шалтгаан, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох зэрэг бэлтгэл ажил хийгдэж байна.

5.2.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ:

Монгол Улсын Засгийн газраас “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Улсын Их Хуралд 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлэв.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтэс өргөн мэдүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тулгуурлан 6 бодлогын хүрээнд дэвшүүлсэн нийт 259 зорилтыг хэрэгжүүлэх 1087 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийв.

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2020-2021 онд хэрэгжүүлж эхлэх 234 зорилтын хүрээний 937 арга хэмжээнээс 455 арга хэмжээ буюу 48.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 2020-2021 оны хэрэгжүүлж дуусгах 75 арга хэмжээ байгаагаас 19 арга хэмжээг хэрэгжүүлж дуусгасан байна.

5.2.3. Бусад

Улсын Их Хурлын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны тайланд хийсэн системчилсэн үнэлгээ:

Улсын Их Хурлын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны тайланд Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагааны тайланд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу системчилсэн үнэлгээг хийв.